

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 9 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны тавдугаар сарын 27-ны 16 цаг 08 минутад эхэлж, 18 цаг 18 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 2 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1.	Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийн тухай	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ж.Нармандахын Төрийн албаны зөвлөлийн тус аймгийн салбар зөвлөлд Ж.Нармандахад шийтгэл ногдуулах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны Б/11 тоот тушаалыг эс зөвшөөрч гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг дэмжсэн тогтоол гаргахаар болов.
2	Ёс зүйн хорооны дүгнэлтийн тухай	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас тус газрын ёс зүйн хороонд гаргасан Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтний ёс зүйтэй холбогдолтой хүсэлтийг шийдвэрлэсэн Ёс зүйн хорооны дүгнэлтийг дэмжсэн тогтоол гаргахаар болов.
3	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгын дагуу бүртгүүлсэн иргэдийг нэр дэвшүүлэх тухай	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгын дагуу Шүүхийн Тамгын газрын шүүгчийн туслахын албан тушаалд бүртгүүлсэн Дэлгэрмаа овогтой Мягмархандыг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлж, албан тоот хүргүүлэхээр шийдвэрлэв.
4	Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн статистик, мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн статистик, мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй Оргодолзангиат овогтой Энхцэцэгийг нэр дэвшүүлж, Эрүүл мэндийн газрын даргад албан тоотоор хүргүүлэхээр шийдвэрлэв
5.	Боловсрол, соёлын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, соёлын албаны дарга, Биеийн тамир, спортын газрын дарга, аймгийн Төв номын сангийн дарга, Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Боловсрол, соёлын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, соёлын албаны дарга, Биеийн тамир, спортын газрын дарга, аймгийн Төв номын сангийн дарга, Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлаж, бүртгэлийг 2016 оны 06 сарын 20-нд хийж, шалгалтыг 06 сарын 21-22 өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.
6	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгад мэргэшлийн шалгалт зарлуулах тухай.	Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн дэс түшмэлийн 7, туслах түшмэлийн 6 хийт 13 ажлын байранд мэргэшлийн шалгалт зарлуулахаар Төв комисст хүргүүлэхээр шийдвэрлэв.